ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТӨВ

ХАНАН ХЭЦ ПОВЕР ХХК

# “ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН” ТӨВ ТӨААТҮГ
# “ХАНАН ХЭЦ ПОВЕР” ХХК ХООРОНД
# ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

“Ханан хэц повер” ХХК нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн хүрээнд дэд бүтцийн болон бусад Түншлэлийн төслүүдийг хэрэгжүүлэх сонирхлоо илэрхийлж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвтэй мэдээлэл солилцох, хамтран ажиллахаар Харилцан ойлголцлын санамж бичгийг доорх нөхцөлөөр байгуулав.

1. “Ханан хэц повер” ХХК гийн сонирхож буй нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээ, аялал жуулчлалын салбарын төслүүдийн холбоотой мэдээллээр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв нь ханган хамтран ажиллахаар

2. “Ханан хэц повер” ХХК нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээ хийхэд шаардлагатай материалыг боловсруулахад Төр хувийн хэвшлийн түншлэлийн төв нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллахаар

3. Өмнөговь аймгийн Гурвантэс суманд “Сэргээгдэх эрчим хүчний төслийг хэрэгжүүлэх” төсөл нь олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, нийтэд үйлчлэх зорилгыг дэмжсэн, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн байхыг талууд харилцан зөвшөөрсөн

4. Харилцан ойлголцлын санамж бичиг нь Талуудын хоорond хамтын ажиллагааг эхлүүлэх үндэс болох ба санамж бичгийн хүрээнд аль нэг тал нь тодорхой гэрээ байгуулах, ямар нэг үйлчилгээ үзүүлэх эсхүл төлбөр төлөх үүрэг хүлээхгүй

5. Харилцан ойлголцлын санамж бичгийг 2 (хоёр) хувь үйлдэж талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг даран тал тус бүр нэг хувийг хадгална

| | |
|---|---|
| **“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ** | **“ХАНАН ХЭЦ ПОВЕР” ХХК** |
| Захирал | Гүйцэтгэх захирал |
| М.АМГАЛАНБААТАР | Э.ЦОНДСҮРЭН |

2025 оны 11-р сарын 18 өдөр

Улаанбаатар хот